

ШИНЭ СЭРГЭЛТ

ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

ТӨРИЙН ХЭМНЭЛТ

ИРГЭДИЙН ТӨСӨВ 2023



Эх сурвалж: Иргэдийн төсөв-2023, Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл, Сангийн яам

АГУУЛГА



2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ

*Дэлхийн засгийн нөхцөл байдал
Төсвийн бодлого-2023*



ТӨСВИЙН ОРЛОГО

*Төсвийн орлогын чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд
Орон нутгийн төсвийн нийт орлого*



ТӨСВИЙН ЗАРЛАГА

*Төсвийн зарлагын чиглэлээр баримталсан бодлого
Орон нутгийн төсвийн нийт зарлага
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхэлсэн арга хэмжээний
санхүүжилт*



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН




НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ


ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дэлхийн эдийн засаг хүндхэн сорилтуудтай тулгарч байна.

Та бүхний мэдэж байгаачлан Орос - Украйны хооронд үүссэн нөхцөл байдал дэлхий даяар хүнс, эрчим хүчний үнийг огцом өсөж, улс орнууд инфляцын дарамтыг нэн тэргүүнд тогтворжуулах мөнгөний эрс хатуу бодлого баримталж, Европын Холбоо эрчим хүчний хямралын эрсдэлд ороод байна.





Дэлхийн улсуудын инфляц



АНУ Европын Холбоо, Австрали тэргүүтэй дэлхийн өндөр хөгжилтэй орнууд инфляцыг бууруулахын тулд бодлогын хүүгээ нэмэгдүүлж байгаа нь хөгжиж буй орнуудад өрийн болон валютын ханшийн дарамтыг бий болгож, эдийн засгийн өсөлт саарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Дэлхийн улсуудын бодлогын хүү



БНХАУ Ковид-19 халдварын тархалтыг зогсоох зорилготой “Тэг Ковид” бодлого хэрэгжүүлж, худалдааны гол боомт хотуудад хөл хорио тогтоосноор дэлхий даяар нийлүүлэлтийн сүлжээ тасалдахад хүрэв. “Тэг Ковид” бодлого болон үл хөдлөх хөрөнгийн салбарын хямралын улмаас дэлхийн хоёр дах том эдийн засаг болох БНХАУ-ын эдийн засаг удааширч байна.


2023 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Дээрх шалтгаануудын улмаас Дэлхийн Банк 2023 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллөө 3.2 хувиас 3 хувь болгож буурууллаа.


ТӨСВИЙН БОДЛОГО-2023

Засгийн газраас 2023 оны төсвийн бодлогыг боловсруулахдаа үнийн өсөлтийн дарамтаас үүдсэн эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн дараах бодлогыг баримталсан.




ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО"-ЫГ ДЭМЖИНЭ.

Эрүүл мэнд, боловсролын салбарт эхлүүлсэн төрийн үйлчилгээний чанар, гүйцэтгэл, хүрэх үр дүнд чиглэсэн төсвийн санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлж, уг шинэчлэлийг бусад салбарт нэвтрүүлэх. Энэ хүрээнд төрийн албаны цалин хөлсний тогтолцоог бүтээмжтэй нь уялдуулж шинэчилнэ.




ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛНЭ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагааны зардалд тавих хяналтыг сайжруулах замаар төрийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг боломжит түвшинд хүртэл бууруулна. Төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, өмнөх жилүүдэд эхлүүлсэн төсөл арга хэмжээг хугацаанд нь дуусгана.



НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ ХУВААРИЛНА.

Хүүхдийн мөнгийг хэрэгцээт бүлэгт чиглүүлэх, уул уурхайн компанийн хандив тусламжийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болгоно.



ЭДИЙН ЗАСГИЙГ ТОГТВОРЖУУЛНА.

Мөнгөний бодлогыг чангаруулан, төсвийн зардлыг хязгаарлаж, алдагдлыг бууруулна. Өрийн удирдлагын стратегийг оновчтой хэрэгжүүлж, гадаад өрийн дарамтыг бууруулахын зэрэгцээ зээлжих зэрэглэлийг хадгалж, эдийн засгийн тогтвортой орчныг дэмжинэ.

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО АЛСЫН ХАРАА-2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн УИХ-ын 52 дугаар тогтоолоор батлагдсан.



ҮНДЭСНИЙ
НЭГДМЭЛ ҮНЭТ
ЗҮЙЛ



ХҮНИЙ ХӨГЖИЛ



АМЬДРАЛЫН ЧАНАР
БА ДУНДАЖ
ДАВХАРГА



ЭДИЙН ЗАСАГ



ЗАСАГЛАЛ



НОГООН ХӨГЖИЛ



АМАР ТАЙВАН,
АЮУЛГҮЙ
НИЙГЭМ




БҮС, ОРОН
НУТГИЙН
ХӨГЖИЛ



УЛААНБААТАР
БА ДАГУУЛ ХОТ

“Алсын хараа-2050” нь Монгол Улсын урт хугацааны буюу дараагийн 30 жилийн хөгжлийн бодлогын бичиг баримт юм.



“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-ын 106 дугаар тогтоолоор батлагдсан.



БООМТЫН
СЭРГЭЛТ



ХОТ
ХӨДӨӨГИЙН
СЭРГЭЛТ



ЭРЧИМ
ХҮЧНИЙ
СЭРГЭЛТ



НОГООН
ХӨГЖЛИЙН
СЭРГЭЛТ



АЖ
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН
СЭРГЭЛТ



ТӨРИЙН
БҮТЭЭМЖИЙН
СЭРГЭЛТ

“Шинэ сэргэлтийн бодлого” нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.

ХЭРЭГЖҮҮЛСЭНИЙ ҮР ДҮНД:



Эдийн засгийн
өсөлт 6%



Нэг хүнд ногдох
үндэсний орлого 2
дахин өсөх



Ажиллах хүчний
оролцооны
түвшин 65%



Боомтын хүчин
чадлыг 3 дахин
нэмэх



Эрчим хүчний
эх үүсвэр 2
дахин өсөх

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ



2022 оны 4-р сард улс орны нөхцөл байдалтай уялдуулан "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийг баталсан ба уг хуульд эдгээр зүйлсийг хориглосон.

Хуулийн хориглох заалтууд:



Тэргүүн дэд, дэд, орлогч дарга нарыг цөөлөх



Тээврийн хэрэгсэл
Суудлын автомашин ашиглахыг хориглох

I Албан тасалгаа

Захиргааны зориулалтаар барилга шинээр

I барихыг хориглох



Дүрэмт хувцас
худалдан авахыг хориглох



Албан томилолт
Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчихыг хориглох



Цахим худалдан авалт

Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээг авахыг хориглох



Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

Хөшөө, дурсгал, хаягжуулалт, орон сууцны фасад, айл өрхийн ариун цэврийн байгууламж гэх мэт зардлыг хориглох

B Бусад хангамж

Гар утасны зардал замын зардал хэвлэлийн зардал, хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг хориглох

Хэмнэлтийн бусад арга

хэмжээ

Бэлэг дурсгал, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох согтууруулах ундаа, их хэмжээгээр бараа,



хориглох

2022 онд 198.0 тэрбум төгрөгийн зардлыг хэмнээд байна. 2023 онд төрийн хэмнэлтийг үргэлжлүүлэхээр дараах бодлогуудыг баримтлан ажиллаж байна.

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ 2023 ОНООС ДАРААХ ТӨСЛҮҮДИЙГ УЛСЫН ТӨСВИЙН БОЛОН ГАДААД ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ



Орон нутгийн хог хаягдлын асуудал.



Нийтийн эзэмшлийн байр, орон сууцны засвар, шинэчлэл.



Орон нутгийн авто замын засвар.



Багийн төв, хорооны засаг захиргааны зориулалттай барилга барих, тохижуулах, засварлах, тоног төхөөрөмж худалдан авах.



Айл, өрхийн ариун цэврийн байгууламж, гудамжны тохижилт.



Хэрэгжих боломжгүй төслүүдийг зогсоох, гэрээ байгуулаагүй төслүүдийг хойшлуулах.





Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх.



ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Төсвийн оновчтой бодлого баримталж, сахилга батыг сахисны үр дүнд төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь жил ирэх тусам буурч байна.



ТӨСВИЙН ОРЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД



Экспортыг эрчимжүүлэх, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд тухайн аймаг, сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, дэмжих, тэдгээрийн тээврийн үйл ажиллагааг саадгүй явуулахад онцгой анхаарч ажиллах;

ТАТВАРЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, мөн харьяа татварын албатай хамтран татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтын бүртгэлийн хяналт тавих ажлыг зохион байгуулах;



Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогын нийлбэр дүнд шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулах, тооцоолох ажлыг харьяа татварын албатай хамтран зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах;


Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр сумын Засаг дарга, Усны газар, сав газрын захиргаа, төвлөрсөн ус хангамжийн байгууллага, татварын алба ус ашиглагчийн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан усны хэмжээг бодитоор тодорхойлон, төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО

Төсвийн төсөлд аймгийн 2023 оны төсвийн нийт орлогыг 35,1 тэрбум төгрөг байхаар тооцож байгаа нь 2022 оны батлагдсан нийт төлөвлөгөөнөөс 3012,2 сая төгрөгөөр илүү буюу 9,4 хувиар нэмэгдсэн байна.

2023 оны нийт орлогыг ангилан харуулъя.



ТАТВАРЫН ОРЛОГО:
31,8 тэрбум Т

ТАТВАРЫН БУС ОРЛОГО:
3,3 тэрбум Т

Орлогын албан татвар:

17,5 тэрбум Т

Хөрөнгийн албан татвар:

6,4 тэрбум Т

Татварын бус орлого:

3,3 тэрбум Т

Бусад орлого:

7,8 тэрбум Т



ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ТӨСӨЛД БАРИМТАЛСАН БОДЛОГО



2023 онд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.



1

Төсвийн бүх шатны байгууллага, төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-ийг мөрдөж, хэмнэлтийн горимд үргэлжлүүлэн ажиллана.

2

Бүтээмжтэй уялдсан уян хатан ЦАЛИН ХӨЛСНИЙ ШИНЭЧЛЭЛИЙГ эхлүүлнэ.

3

Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа зарим салбаруудад ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ нь үндэслэн санхүүжилт хуваарилах тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4

Хүүхдийн мөнгийг ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ЧИГЛҮҮЛНЭ.

5

“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ыг хэрэгжүүлнэ.

ҮР АШИГТАЙ БАЙХ

Санхүүжилтийн механизмыг нь өөрчлөх замаар нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг салбаруудын төсвийг нь дахин хуваарилж, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.

ИЛ ТОД ШУУРХАЙ БАЙХ

Бүх салбарын төрийн үйлчилгээг цахимжуулж, мэдээллийг ил тод, ойлгомжтой болгоно. Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүнд сурталгүй хүргэнэ.

ХЭМНЭЛТТЭЙ БАЙХ

Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд бүх шатны төсвийн байгууллагууд тэвчиж болох зардлуудыг хэмнэн, үрэлгэн байдлыг хязгаарлан ажиллана.

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Төрийн хэмнэлтийн тухай хууль нь төсвийн бүх шатны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаандаа заавал дагаж мөрдөх хязгаарлалтуудыг хуульчлан тогтоосон.

Монгол
Улсын 2023
оны нэгдсэн
төсвийн урсгал
зардлын төсөл
боловсруулахад
баримталсан
зарчим

Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлогын хүрээнд хийж буй томоохон ажлуудын нэг нь төрийн албан хаагчдын цалингийн тогтолцоог өөрчлөх юм.



ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 100
ДУГААР КОНВЕНЦЫН ЗАРЧИМ:
АДИЛ ҮНЭЛЭМЖТЭЙ ХӨДӨЛМӨР = АДИЛ ЦАЛИН



Уг зарчимтай уялдуулан 2022 онд төрийн үйлчилгээний 272 ялгаатай цалинг 59 ялгаатай цалин болгон шинэчилсэн. Уг ажлыг үргэлжлүүлэн 2023 онд дараах шинэчлэлтийг хийнэ.



Төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагчдын 153 ялгаатай цалинг 20 ялгаатай суурь цалин болгож шинэчилнэ.



Шатлалын тоог бууруулахдаа тухайн зэрэглэлийн өндөр шатлал буюу 5 дахь шатлал руу ахиулан өөрчлөлтийг хийх юм. Ингэснээр дундаж цалин тодорхой хэмжээнд өсөх төдийгүй хөдөлмөрийг жигд үнэлэх шударга тогтолцоонд шилжиж байна.



Цалинтай холбоотой дараагийн шинэчлэл бол төрд ажилласан жил бүрийг 1 хувиар тооцож нэмэгдэл олгодог болох юм.

ОДООГИЙН НЭМЭГДЭЛ

0-5 жил = 0% 6-10 жил = 5%
11-15 жил = 10% 16-20 жил = 15%
21-25 жил = 20% 26-с дээш жил = 25%

Жишээ:
6 жил ажилласан
10 жил ажилласан

ШИНЭЧИЛСЭН НЭМЭГДЭЛ

Эхний жил = 0%
2 жил = 1%
3 жил = 2%
4 жил = 3% 25 жил = 24%
26-с дээш жил = 25%

Жишээ:
6 жил ажилласан = 6% 10 жил ажилласан = 10%

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА



2023 онд аймгийн төсвийн нийт суурь зарлагыг 43,4 тэрбум төгрөг байхаар тооцсон нь 1624,0 сая төгрөгөөр буурсан.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР

ЭХЭЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ (2023 ОН)

СУМ	ТӨСӨЛ	ХУГАЦАА	ТӨСӨВТ ӨРТӨГ /Сая/	САНХҮҮЖИХ ДҮН /Сая/
БОЛОВСРОЛЫН САЛБАРТ				
ЗУУНМОД	СПОРТЫН ТӨРӨЛЖСӨН СУРГУУЛИЙН БАРИЛГА, 640 СУУДАЛ	2019-2023	5,284.1	311.5
БАТСҮМБЭР	СУРГУУЛИЙН БАРИЛГА, 920 СУУДАЛ	2019-2023	9,920.1	946.2
БҮРЭН	БАГА СУРГУУЛИЙН БАРИЛГА	2019-2023	1,177.7	89.0
ЭРДЭНЭСАНТ	ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, 100 ОР	2020-2023	1,157.8	112.7
ЗААМАР	СУРГУУЛИЙН БАРИЛГА, 320 СУУДАЛ	2020-2023	1,961.7	462.7
ДЭЛГЭРХААН	СУРГУУЛИЙН БАРИЛГА, 160 СУУДАЛ	2020-2023	1,327.2	227.2
АРХУСТ	СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРЫН БАРИЛГА, 40 ОР	2020-2023	802.1	102.2
МӨНГӨНМОРЬТ	СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРЫН БАРИЛГА, 75 ОР	2020-2023	1,014.9	114.9
БАЯНХАНГАЙ	ДОТУУР БАЙРЫН БАРИЛГА, 50 ОР	2020-2023	1,114.3	199.7
УГТААЛЦАЙДАМ	ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, 150 ОР	2021-2023	1,512.0	212.0
БАЯНЖАРГАЛАН	ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ӨРГӨТГӨЛ	2021-2023	885.4	85.4
ЛҮН	ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, 150 ОР	2021-2023	1,757.0	257.0
БҮРЭН	ДОТУУР БАЙРЫН БАРИЛГА БУУЛГАЖ, ШИНЭЭР БАРИХ, 160 ОР	2022-2023	3,330.8	3,130.8
ЖАРГАЛАНТ	ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, 150 ОР	2022-2023	1,499.7	1,299.7
ЗУУНМОД	ДОТУУР БАЙРЫН БАРИЛГА, 160 ОР	2022-2023	2,095.6	1,675.6

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭХЭЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ (2023 ОН)

СУМ	ТӨСӨЛ	ХУГАЦАА	ТӨСӨВТ ӨРТӨГ /Сая/	САНХҮҮЖИХ ДҮН /Сая/
<i>БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРТ</i>				
ЖАРГАЛАНТ	СПОРТ ЗААЛЫН БАРИЛГА	2021-2023	1,383.6	1,083.6
<i>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ</i>				
ТӨВ АЙМАГ	ОРОН-НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ "ШИНЭ ХӨДӨӨ" ТӨСӨЛ	2022-2023	4,400.0	4,112.0
<i>ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ</i>				
ЭРДЭНЭСАНТ	СУМЫН ТӨВИЙН АВТО ЗАМ, 3.2 КМ	2019-2023	1,685.7	55.7
МӨНГӨНМОРЬТ	БАГАНУУР-МӨНГӨНМОРЬТ ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ, 60 КМ	2019-2023	47,140.3	8,515.6
ЗУУНМОД	ЗУУНМОД-МАНЗУШИР ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ, 7.0 КМ	2020-2023	6,777.5	498.1
ЗУУНМОД	ЗУУНМОД СУМЫН ТӨВӨӨС ХӨШИГИЙН ХӨНДИЙН ШИНЭ НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМ	2021-2024	8,808.6	891.7
АРГАЛАНТ	БАРУУН ЧИГЛЭЛД АВТО ЗАМААС АРГАЛАНТ СУМЫН ТӨВ ХҮРТЭЛХ, АВТО ЗАМ, 7.1 КМ	2022-2023	8,424.1	7,124.1
УГТААЛЦАЙДАМ ЦЭЭЛ, ЗААМАР	УГТААЛЦАЙДАМ, ЦЭЭЛ, ЗААМАР СУМДЫН ХОЛБОХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ, 122.4 КМ	2022-2025	115,862.7	27,578.9
БОРНУУР	УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС БОРНУУР СУМЫН ДУГАН ХАД АМ ХҮРТЭЛХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ, 8.5 КМ	2022-2024	8,499.5	3,305.2
БАТСҮМБЭР	МАНДАЛЫН ГОЛЫН ТӨМӨР БЕТОН ГҮҮРИЙН ШИНЭЧЛЭЛ	2021-2023	1,260.0	259.9

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭХЭЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ (2023 ОН)

СУМ	ТӨСӨЛ	ХУГАЦАА	ТӨСӨВТ ӨРТӨГ /Сая/	САНХҮҮЖИХ ДҮН /Сая/
БОЛОВСРОЛЫН САЛБАРТ				
ЗУУНМОД	ХҮМҮҮН ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛИЙН А БАЙРЫН БАРИЛГЫН ИХ ЗАСВАР	2021-2023	988.3	254.7
ТӨВ АЙМАГ	БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	2022-2023	1,573.8	1,433.8
СОЁЛЫН САЛБАРТ				
БАЯНЧАНДМАН Б	СОЁЛЫН ТӨВИЙН БАРИЛГА, 250 СУУДАЛ	2020-2023	1,782.7	323.9
БОРНУУР	СОЁЛ, СПОРТЫН ТӨВИЙН БАРИЛГА, 300 СУУДАЛ	2020-2023	2,471.6	477.1
БАЯНЖАРГАЛАН	СОЁЛ, СПОРТЫН ТӨВИЙН БАРИЛГА, 250 СУУДАЛ	2020-2023	1,592.7	392.7
СЭРГЭЛЭН	СОЁЛ, СПОРТЫН ТӨВИЙН БАРИЛГА, 250 СУУДАЛ	2020-2023	1,660.9	460.9
ЗУУНМОД	МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ АРХЕОЛОГИ, ПАЛЕОНТОЛОГИ, УГСААТНЫ МУЗЕЙ, ЛАБОРАТОРИ	2021-2024	22,455.2	5,740.4
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ				
ЭРДЭНЭСАНТ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГЫН ӨРГӨТГӨЛ	2020-2024	1,096.2	355.2
ӨНДӨРШИРЭЭТ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА	2020-2023	1,557.8	259.9
БАЯНЦОГТ	ЭМНЭЛГИЙН БАРИЛГА, 15 ОР	2021-2023	1,798.1	199.2
ЭРДЭНЭ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА, 15 ОР	2021-2023	2,455.8	871.7
ЗУУНМОД	НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН БАРИЛГА, 50 ОР	2022-2023	5,475.7	3,902.8
ТӨВ АЙМАГ	ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	2022-2023	1,700.0	1,560.0

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР

ЭХЭЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ (2023 ОН)

СУМ	ТӨСӨЛ	ХУГАЦАА	ТӨСӨВТ ӨРТӨГ /Сая/	САНХҮҮЖИХ ДҮН /Сая/
ТӨРИЙН ЗАХИРГАА				
АРХУСТ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАРИЛГЫН ИХ ЗАСВАР	2021-2023	455.5	45.5
ХУУЛЬ ХЯНАЛТЫН САЛБАРТ				
ЗУУНМОД	ШШГГ-ЫН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БҮХИЙ ТӨВ	2022-2023	2,139.9	1,327.4
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРТ				
ЗУУНМОД	ЗУУНМОД ХОТЫН 2*2000м3 БАГТААМЖТАЙ УСАН САН, УСАН ХАНГАМЖИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ	2018-2023	5,771.4	214.1
ЗУУНМОД	ҮЕРИЙН УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ	2020-2023	804.2	116.1
ЗУУНМОД	ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН ГАДНА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ	2022-2024	6,036.4	3,302.7
БАЯНЧАНДМАН Ь, БОРНУУР, СЭРГЭЛЭН, ЭРДЭНЭ	ТӨВИЙН БОЛОН ГЭР ХОРОЛЛЫН ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ, ТОХИЖИЛТ	2022-2024	15,792.9	4,368.1
ТӨВ	"ХӨШИГИЙН ХӨНДИЙН ШИНЭ ХОТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ" ТӨСӨЛ	2022-2024	171,352.6	66,950.0
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ				
ЗУУНМОД	ДУЛААНЫ СТАНЦЫН ХАЛААЛТЫН 1, 2, 3, 4, 5, 6, 7 ДУГААР ХЭСГИЙН 2 ДУГААР ХЭЛХЭЭНИЙ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ӨРГӨТГӨЛ	2022-2024	11,590.5	3,593.0
ЗУУНМОД	ШИНЭ НИСЭХ-ЗУУНМОД СУМЫГ ХОЛБОХ 110 кВ-ЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ, 110/35/10 ДЭД СТАНЦ	2022-2024	18,632.5	6,387.6

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) нь нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэлийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.



ОНХС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэдийн оролцоо



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙН ХЭМЖЭЭ 16,4 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР БАТЛАГДЛАА. ҮҮНЭЭС 27 СУМАНД 9,0 ТЭРБУМ ТӨГРӨГ, АЙМАГТ 7,3 ТЭРБУМ ТӨГРӨГ.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ХАНДИВ ТУСЛАМЖИЙГ ТӨВЛӨРҮҮЛСНЭЭ



„Тухайн орон нутгийн иргэдийн ажил

ТӨРИЙН ТӨСӨВ САНХҮҮГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ЦАХИМ ХУУДАСНУУД


ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН СИСТЕМ

ОНХС-аар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл авах болон санал өгөх боломжтой.



ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЦАХИМ СИСТЕМ

Гадаад эх үүсвэрээр санхүүжиж байгаа төсөл хөтөлбөр, түүний хэрэгжилтийн мэдээллийг авах боломжтой.



ИЛ ТОД, ИРГЭДИЙН ТӨСӨВ

Тухайн жилийн УИХ-д өргөн барьсан төсвийн төсөл, батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэл зэрэг төсвийн талаар бүх төрлийн мэдээллийг авах боломжтой.



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМ


Төрийн худалдан авах үйл ажиллагааны хүрээнд зарлагдсан тендерийн тухай мэдээлэл, бүртгэл, шалгаруулалт зэрэг үйл ажиллагаа явагддаг.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ЦАХИМ СИСТЕМ

Улсын төсвөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төслүүд, түүний хэрэгжилтийн мэдээллийг авах боломжтой.

bprz://riy|C1ПУе81теп1.dou.tp/



ШИЛЭН ДАНСНЫ СИСТЕМ

Төсвийн хэрэгжилтийн гүйлгээний мэдээллийг сар бүрээр авах боломжтой.



Та дараах холбоосоор хандан санал
хүсэлтээ илгээнэ үү.

[TOV.KHURAL.MN](https://tov.khural.mn)

